 6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
 7. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам"-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
 8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн

хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 95,570.7 төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		86,133.9	86,133.9
Авлага	1,193.9	-	(1,193.9)
Бараа материал	61,055.7	65,512.4	4,456.7
Үндсэн хөрөнгө	1,427,307.4	1,433,481.4	6,174.0
Нийт хөрөнгө	1,489,557.0	1,585,127.7	95,570.7
Өр төлбөр	5,013.0	-	(5,013.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,484,544.0	1,585,127.7	100,583.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,489,557.0	1,585,127.7	95,570.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 86,133.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл 4,456.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 83,202.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, БШУГ, Тайваны хүүхдийн сангаас 2,751.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй шилжүүлснийг бүртгэж, 76,139.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5,374.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан нь нөлөөлсөн;
3. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 6,174.0 мянган төгрөгөөр нэмэгдэхэд Төв аймгийн БШУГ-аас 4,147.3 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сургалтын техник хэрэгсэл, Төв аймгийн Баянжаргалан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 25,641.0 мянган төгрөгийн биеийн хашаа, Туваан сангаас 17,500.0 мянган төгрөгийн, Тайваны хүүхдийн сангаас 10,010.0 мянган төгрөгийн аж ахуйн эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн нь нөлөөлсөн;
4. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 100,583.7 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн санхүүгийн тайланг улсын төсвийн санхүүгийн тайланд шилжүүлсэнтэй холбоотойгоор тайлант үеийн үр дүн 1,585,127.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.
5. Авлага дансны үлдэгдэл 1,193.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татаас санхүүжилтийн авлагыг хүлээн авснаас шалтгаалсан;
6. Өглөг дансны үлдэгдэл 5,013.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш халаалтын 3,819.1 мянган, хоолны тооцооны төлөгдөөгүй үлдэгдэл 1,193.9 мянган төгрөгөөр өр төлбөрийг барагдуулсан нь нөлөөлсөн байна;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 745,294.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 745,294.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 15,892.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 761,186.5 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 15,892.1 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 635,554.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 125,632.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 635,554.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 125,632.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 1,665.4 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 1,101.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 649,337.8 мянган төгрөг буюу 88,8 хувьтай байгаа нь үндсэн цалин хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 82,859.2 мянган, байр ашиглалттай холбоотой зардлыг 749.0 мянган, эд хогшил худалдан авах зардлыг 166.6 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 234.5 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 431.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, нормативд зардлыг 1,620.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	1,901.9	1,901.7	(0.2)	100.0
2	80312-Сургалт семинар	950.9	810.6	(140.3)	85.2
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,187.2	2,187.2	-	100.0
4	81801-Үдийн цай хөтөлбөр	35,450.8	35,450.8	-	100.0
5	81806-Дотуур байрны үйлчилгээ	52,615.7	44,607.5	(8,008.2)	84.8
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	11,990.0	11,990.0	-	100.0
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	4,279.2	4,279.2	-	100.0
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	468,526.0	393,386.7	(75,139.3)	84.0
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	57,652.8	56,472.4	(1,180.4)	98.0
10	81848-Сурах бичгийн түрээс	1,035.8	0.0	(1,035.8)	-
Дүн		636,590.3	551,086.1	(85,504.2)	86.6
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	103,434.2	103,331.2	(103.0)	99.9
2	80112-Нийтлэг үйлчилгээ	32,889.2	32,387.7	(501.5)	98.5
Дүн		136,323.4	135,718.9	(604.5)	99.6
Нийт дүн		772,913.7	686,805.0	(86,108.7)	88.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 118,982.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 6 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 25,267.8 мянган, 3 багшид өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмжид 91,164.8 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 2,550.0 мянган нийт 118,982.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав..

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуульд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны батлагдсан нийт зардлын 414,137.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,141.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,899.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 34,280.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан боловч орон нутгийн төсвөөс санхүүждэг гэрэл, цахилгааны зардлыг 2,434.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 143 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 13 удаагийн мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 36,439.0 мянган төгрөгийн ТӨА-2023/118/НА-СТА-ТШЗ

орлогын гүйлгээг 34,878.3 мянган төгрөгөөр буюу 1,560.7 мянган төгрөгөөр илүү байршуулж, 12 удаагийн 188,313.8 мянган төгрөгийн орлого, 9 удаагийн 146,326.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Балансын дансны жагсаалт"-ын дагуу тайлагнагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

2. Хоол хүнсний 4,284.6 мянган төгрөгийн материалын үлдэгдэл нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

3. Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 1 иргэн, байгууллагын 798.3 мянган төгрөгөөр илүү, 3 иргэн, байгууллагын 322.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж

заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөв.

4. 2022 онд хийгдсэн дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн сургуулийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг "Уваа уул Аудит" ХХК гүйцэтгэж, 1 зөвлөмж, 5,013.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснээс Төв аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр бүрэн хэрэгжүүлсэн гэж хүргүүлсэн боловч гүйцэтгэлийн үе шатанд шалгахад 48.8 хувийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,773.5	1	4,773.5	100.00
Зөвлөмж	1	5,013.0	0	-	-
Нийт дүн	2	9,786.5	1	4,773.5	48.8

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэх, гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,490,578.1 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс, аудитын явцад залруулав.

Үүнд: **Залруулсан алдаа:**

1. Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүн Хувь хүний орлогын албан татварын цахим тайлангийн дүнгээс 1,021.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсаныг;
2. Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,489,557.0 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн тус тус залруулан тайлагнуулав.

Аудитаар нийт 2,417.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 797.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,620.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Үдийн цайны зардлыг батлагдсан нормативаас 797.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 237 дугаар тогтоолын 1-д "Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-т "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 110 нэр төрлийн 90,321.4 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.3 Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Стандарт, хууль тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, баталж мөрдөх.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Байгууллагын нэр дээр ХААН банканд зориулалт тодорхойгүй 5730009143 тоот данс бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11-т "Банкинд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох", 35 дугаар зүйлийн 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно. гэж заасныг мөрдөөгүй байна", 35.5-т "Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зориулалт тодорхойгүй дансыг хаах.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон тоо болон суралцагчдын тоог тогтмол тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсийн дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүн Хувь хүний орлогын албан татварын цахим тайлангийн дүнгээс 1,021.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	1,021.1			1	1,021.1	1	1,021.1				
Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,489,557.0 мянган төгрөгийг залруулсан.	1	1,489,557.0	1	1,489,557.0			1	1,489,557.0				
Дүн	2	1,490,578.1	1.0	1,489,557.0	1.0	1,021.1	2.0	1,490,578.1	-	-	-	-

Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шалгагдагч байгууллагын үдийн цайны зардлыг батлагдсан нормативаас 797.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.	1	797.0	1	797.0								
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 110 нэр төрлийн 90,321.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1				1	-						
Байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн НБББББ-гүй байна.	1						1	-				
Тус байгууллага нь арилжааны банканд /ХААН банканд 5730009143-Касс/ 1 харилцах данстай байна.	1						1	-				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.	1	-					1	-				
Дүн	5	797.0	1	797.00	1	-	3	-				

Төв аймгийн Баянжаргалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 143 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 13 удаагийн мэдээлэл хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 36,439.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 34,878,300.00 төгрөгөөр буюу 1,560.7 мянган төгрөгөөр илүү байршуулж, 12 удаагийн 188,313.8 мянган төгрөгийн орлого, 9 удаагийн 146,326.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.	1	336,200.6			1	336,200.6		
Дүн	1	336,200.6			1	336,200.6		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 4,284.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	4,284.6			1	4,284.6		
2022 онд хийгдсэн дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн сургуулийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна.	1						1	
Гүйцэтгэлд суурилсан төсвийг цөөн нэр төрлөөр баталснаас шалтгаалж, тээвэр шатахуун, томилолт, сургалт, хөрөнгө бэлтгэх зэрэг зардлуудыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын ангилал, дансдаар ангилж бүртгээгүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тайлагнаагүй байна.	1				1	-		
Шалгадагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 1 иргэн, байгууллагын 798.3 мянган төгрөгөөр илүү, 3 иргэн, байгууллагын 322.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	1,120.3					1	1,120.3
Дүн	4	5,404.9	-	-	2	4,284.6	2	1,120.3
Нийт дүн	5	341,605.50	-	-	3.00	340,485.20	2	1,120.30